**ОРХОН АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 05 сарын 11 -ны өдөр Дугаар А/41 Эрдэнэт

“Амны хаалтаа зүүцгээе” аяныг
эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дах заалт, Монгол Улсын Шадар сайд, Улсын Онцгой Комиссын даргын 2020 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн удирдамжийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Амны хаалтаа зүүцгээе” аяныг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, үйл ажиллагааны удирдамжийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
2. Үйл ажиллагааг зохион байгуулахад шаардлагатай 717.700 /долоон зуун арван долоон мянга долоон зуун төгрөг/-ийг хичээл үйдвэрлэл, дадлагын зардлаас гаргахыг Салбарын санхүү бүртгэл мэдээлэл нягтлан бодохын ажилтан /Н.Чулуун-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтийг хангаж тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж мэргэжил аргазүйгээр хангаж ажиллахыг НЭМТ-ийн Халдвар судлаач /Б.Билгүүнээ/-д даалгасугай.

ДАРГА Ц.МӨНХЦЭЦЭГ

5043446 2020030036

My doc. EMG-iin dargiin tushaal

Эрүүл мэндийн газрын даргын
2020 оны 05 дугаар сарын 11-ны өдрийн
А/41 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн дарга: - Өсвөр үе, залуучуудын кабинетийн их эмч

Гишүүд:
- Нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлт осол гэмтэл хариуцсан ажилтан
- Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдлын асуудал хариуцсан ажилтан
- Сум, өрхийн эрүүл мэнд, ахмад настны тусламж үйлчилгээ хариуцсан ажилтан
- Сэтгэлзүйн тусламж үйлчилгээ хариуцсан ажилтан
- Зураглаач

Нарийн бичгийн дарга:
- Халдварт өвчний тандалт сэргийлэлт хариуцсан ажилтан

Эрүүл мэндийн газрын даргын
2020 оны 05 дугаар сарын 11-ны өдрийн
А/41 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**"АМНЫ ХААЛТАА ЗҮҮЦГЭЭЕ" АЯН" - ыг зохион байгуулах үйл ажиллагааны удирдамж**

**Үндэслэл:**

SARS –COV -2 халдвар дэлхийн 215 улс оронд бүртгэгдэж, нийт 3.8 сая хүн өвчилж 265 мянган хүн нас барж, 1,299,361 хүн эдгэрч уг өвчний улмаас 2 сая хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлж байна.

Монгол Улсад 2020.05.06-ний байдлаар коронавирусын 41 тохиолдол бүртгэгдэж, 13 хүн эмнэлгээс гарч, 28 хүн өвчний улмаас ХӨСҮТ-д хэвтэн эмчлүүлж, нийт бүртгэгдсан тохиолдлууд 100% гаднаас зөөвөрлөгдөн орж ирсэн байна. Улсын хэмжээнд гэрийн ажиглалтанд 1042 хүн байгаагаас Орхон аймгийн хэмжээнд 26 иргэн байна.

**Зорилго:** Аймгийн хүн амыг SARS–COV-2 халдвараас урьдчилан сэргийлж болзошгүй эрсдэлээс хамгаалах, иргэдийн оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлж халдвараас сэргийлэх зөв дадал, хэвшлийг төлөвшүүлэх.

**Зорилт:**

**1.** Зорилтот бүлгийн иргэдийг амны хаалт болон урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны гарын авлагаар хангана.

**2.** **А**мны хаалтны зөв хэрэглээг сурталчилах видео бичлэг бэлтгэн, сургалтын материалын хамт цахимаар түгээнэ.

**Зохион байгуулах байгууллага:** Нийгмийн эрүүл мэндийн төв

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

| № | Хэрэгжүүлэх ажил | Хугацаа | Хариуцах эзэн |
|---|---|---|---|
| 1 | "Амны хаалтаа зөв зүүцгээе" уриалгыг цахим орчинд өрнүүлэх | 5 дугаар сарын 11-25 | Ажлын хэсэг |
| 2 | зорилтот бүлгийн иргэдэд амны хаалт болон COVID-19-ын халдвараас урьдчилан сэргийлэх гарын авлага, сургалтын материал тараах | 5 дугаар сарын 12,19,26 | Ажлын хэсэг |
| 3 | "Амны хаалтаа зөв зүүцгээе" уриалгын ялагчийг шалгаруулан, урамшуулах | 5 дугаар сарын 27 | Ажлын хэсэг |

Хүрэх үр дүн:

1. Иргэдийн дунд амны хаалт хэрэглэх хөдөлгөөн өрнүүлж, иргэн бүр амны хаалтаа зөв хэрэглэж хэвшсэн байна.
2. Зорилтот бүлгийн иргэдийг амны хаалтаар ханган, мэдээлэл сургалт сурталчилгаанд хамруулан, зөв дадал эзэмшүүлэх.

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:

ХӨТСХА Ч.Анужин Ч.АНУЖИН

ХЯНАСАН:НЭМТ А.БАЯРХҮҮ

**Шаардагдах төсөв:**

| № | Хэрэглэгдэх материал | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нэгжийн үнэ | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд маск тараах ажлын төсөв** | | | | | |
| Сургалт суртачилгааны материал хийх төсөв | | | | | |
| 1 | Шохойт цаас | Боодол | 5 | 5.500 | 27.500 |
| 2 | Ламинаторын цаас | Ширхэг | 250 | 250 | 62.500 |
| 3 | Хор | Ширхэг | 6 | 4.000 | 24.000 |
| 4 | Цоологч | Ширхэг | 2 | 2.500 | 5.000 |
| 5 | Утас | Метр | 10 | 10.000 | 10.000 |
| 6 | Тасдагч | Ширхэг | 1 | 33.000 | 33.000 |
| 7 | Ламинаторын машин | Ширхэг | 1 | 143.000 | 143.000 |
| 8 | Амны хаалтны гадна даавуу | Метр | 15 | 4.000 | 60.000 |
| Амны хаалт хийх төсөв | | | | | |
| 9 | Амны хаалтны дотор даавуу | Метр | 15 | 2.000 | 30.000 |
| 10 | Амны хаалтны резин | Метр | 2,5 | 4.000 | 10.000 |
| 11 | Оёдлын утас | Кг | 1 | 15.000 | 15.000 |
| 12 | Амны хаалтны уут | Ширхэг | 500 | 50 | 25.000 |
| 13 | Нийт | | | **223.300** | **445.000** |
| Цахим уралдааны төсөв | | | | | |
| 14 | 1 удаагийн амны хаалт /Цахим уралдааны шагнал/ | Ширхэг | 60 | 1.000 | 60.000 |
| 15 | Бестселлер ном /Цахим уралдааны шагнал/ | Ширхэг | 6 | 24.450 | 146.700 |
| 16 | Гар ариутгагч | Ширхэг | 6 | 11.000 | 66.000 |
| 17 | Нийт | | | **36.450** | **272.700** |
| 18 | Нийт зардал | | | **259.750** | **717.700** |

Төсөв гаргасан: ЭМЭЗТТХМ Д.Отгондэлгэр

Төсөв хянасан:ССБМНБ Н.Чулуун-Эрдэнэ